

Үндсэн хуульд заасан хүний халдашгүй эрхийг хангах талаарх Монгол Улс, АНУ-ын шүүхийн ажиллагаа

Гомбосүрэнгийн ГАНЗОРИГ*
ДЕРРИК Ватсон*

-
- I. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний халдашгүй эрх
 - II. Хувийн байдлыг тогтоох ажиллагаа, шүүхээс тогтоосон жишиг
 - III. Практикийн ажилтнуудын үзэл бодол
 - IV. Монгол Улсын олон улсын гэрээ
 - V. АНУ-ын шүүхийн ажиллагаа
 - VI. Хүний халдашгүй эрхийн онол
 - VII. Дүгнэлт, санал
-



* "Ganzorig consulting" хуулийн фирмийн гүйцэтгэх захирал, ✉

* Америкийн Нэгдсэн Улсын Хавай муж дахь дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч.



Үндсэн хуульд заасан хүний халдашгүй эрхийг хангах талаарх Монгол Улс, АНУ-ын шүүхийн ажиллагаа

Гомбосүрэнгийн ГАНЗОРИГ
ДЕРРИК Ватсон

"Ganzorig consulting" хуулийн фирмийн гүйцэтгэх захирал.
Америкийн Нэгдсэн Улсын Хавай муж дахь дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч

Энэ өгүүлэл нь, шүүгдэгчийн хувийн байдал, түүний дотор хүний эмзэг мэдээлэл болох ял шийтгэгдсэн байдлыг шалгаж, шүүхэд танилцуулах, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах талаарх Монголын болон Америкийн хуулиар тогтоосон журмыг товчхон авч үзэж, харьцуулсан дүгнэлт хийж, энэ чиглэлээрх Монгол Улсын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох зарим саналыг танилцуулж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилготой болно.

I. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬД ЗААСАН ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ ЭРХ

Үндсэн хуульд хүний халдашгүй эрх, эрх чөлөөний суурь зарчмыг тодорхойлж, түүнийг хамгаалах, баталгаажуулах, хэрэгжүүлэх арга хэлбэр, журмыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэчилсэн хууль (цаашид ЭХХШТХ хууль) болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай салбар хуулиудаар нарийвчлан тогтоож өгсөн байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т *"халдашгүй ... байх эрхтэй. Иргэний хувийн ... нууцын халдашгүй байдлыг хуулиар хамгаална"* гэж зааж, хүний халдашгүй байдлыг Үндсэн хуулийн эрх болгон тодорхойлсон байна.

Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт *"Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд ... гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн ... байдлыг харгалзан үзнэ"*² гэж дурдсан тул "хувийн байдал" -ыг тогтоох нь шүүх, ял шийтгэл оногдуулахад харгалзан үзэх чухал ач холбогдолтой нөхцөл болж байна. Эрүүгийн хуульд заасан "гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал" гэдэг нэр томъёог хэрхэн ойлгож, хэрэглэхийг тодорхой болгохын тулд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, ЭХХШТХ, Эрүүгийн хуулиудыг зэрэгцүүлэн авч үзэж, хооронд нь уялдуулан тайлбарлах зайлшгүй шаардлагатай байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.12-т *"...ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх нь хүний эмзэг мэдээлэлд хамаарна"* гэж, 9.1-д *"Энэ хуулийн 4.1.12-т заасан ... хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна"*³ гэж тус тус заасан байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай шинэчилсэн хуулийг 2021

¹ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.


² Эрүүгийн хууль (2015)-ийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail/11634>.

³ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)-ийн 4.1 дүгээр зүйлийн 12, 9.1 дүгээр зүйл, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>.



оны 12 сарын 17 өдөр баталсан байна. Энэхүү шинэчилсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлэн, 2017 онд батлагдсан ЭХХШТ хуулийн 1.11 дүгээр зүйлийн 1 дэхь хэсгийг "Иргэний хувийн ... мэдээллийг хуулиар хамгаална" гэж, 8.3 дугаар зүйлийн 3-т "Прокурор, мөрдөгч ... хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй"⁴ гэж, 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар батлагдсан Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлийн 1 дэхь хэсгийг "Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"⁵ гэж тус тус өөрчлөн найруулсан байна. Эндээс харахад, ял эдэлсэн байдал нь хүний эмзэг мэдээлэлд хамаарна, хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна, хувийн нууцыг хуулиар хамгаална, хувийн нууцыг задруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцно гэж тус тус зааж, Үндсэн хуульд заасан хүний халдашгүй эрхийг хамгаалах зорилготой эрх зүйн, харилцан уялдаатай, тодорхой тогтолцоог бий болгох зарим алхамыг хэрэгжүүлсэн гэх дүгнэлт хийж болохоор байна. Эдгээр хуулиудын салшгүй уялдаа холбоотой байдлыг График нэгд харуулав.

График 1: Хүний халдашгүй эрхийг хамгаалсан хуулиудын уялдаа холбоо



⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 1. 11 дүгээр зүйлийн 1, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>.

⁵ ЭХ-ийн 13.11 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэг.

II. ХУВИЙН БАЙДЛЫГ ТОГТООХ АЖИЛЛАГАА, ШҮҮХЭЭС ТОГТООСОН ЖИШИГ

Хүний хувийн байдлыг тогтоох ажиллагааны журмын талаар ЭХХШТ хуулийн 31.10 дугаар зүйлийн 1-д "Мөрдөгч энэ хуулийн 31.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт (31.3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах 4. Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох ... ажиллагааг 12 цагийн дотор явуулна), 31.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт (31.6 дугаар зүйл. 4. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох ... ажиллагааг явуулна) заасан "хувийн байдлыг тогтоох зорилгоор дараах ажиллагааг явуулна"⁶ гэж дурдсан байна. Өнөөгийн Эрүүгийн хууль, ЭХХШТ хуулийн зорилгоос харахад, ял эдэлсэн байдлыг тогтоох ажиллагаа нь, шүүхийн ял шийтгэл оногдуулах, хэргийн зүйлчлэлийг тогтоох гэсэн хоёр гол зорилгыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой гэж ойлгогдож байна. Эдгээр нь хоёр тусдаа ойлголт юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.2-т заасан дагуу "Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн"⁷ эсэхийг шалгаж, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлын талаар шүүх дүгнэлт хийх шаардлагатай гэдэг нь тодорхой байна. Энэ нөхцөл нь хэргийн зүйлчлэлд хамаарахгүй юм. Шүүхийн ял шийтгэл оногдуулах ажиллагаатай холбогдох, тухайн хүний ял эдэлсэн байдал, эмзэг мэдээллийг шалгах энэ ажиллагааг, мөрдөн байцаалтын шатанд хийх бодит хэрэгцээ шаардлага цагдаад нэгэнт байхгүй тул, эл ажиллагааг шүүх өөрөө хийдэг байхаар, Хуулийн энэ заалтын гүйцэтгэх үе шат, субъектыг өөрчилж, хуульчлан тогтоох нь зохистой байж болох юм. Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 2-т "Энэ хуулийн тусгай ангид заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй" гэсэн, мөн Эрүүгийн хуулийн өөр бусад зарим зүйл хэсэгт, тухайлбал, 17.1 дүгээр зүйлийн 3.1 дэх хэсэгт дурдсан "байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон"⁸ гэсэн заалт нь хэргийн зүйлчлэлийг тогтооход ач холбогдолтой байх тул мөрдөн байцаалтын шатанд прокурор, мөрдөгч ял эдэлсэн байдлыг тогтоох үүрэгтэй байх юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 2.7-д "урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"⁹ гэж хүчингийн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчийн ялыг хүндрүүлэх нөхцөл болгон хуульд заасан тул энэ төрлийн хэргийн хувьд шүүх бус, харин прокурор, мөрдөгч ял эдэлсэн байдлыг шалган тогтоох шаардлагатайг үгүйсгэх үндэслэлгүй юм.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар "хүний эмзэг мэдээлэл" гэх нэр томъёог танилцуулж, ял эдэлсэн байдлыг "хүний эмзэг мэдээлэл"-д хамааруулахаар анхлан заасан байна. Мөн өдрийн хуулиар ЭХХШТ хуулийн 7 зүйл хэсэгт "хүний эмзэг мэдээлэл" гэсэн ойлголтыг шинээр нэмж, өөрчлөлт оруулсан боловч, Хуульд байгаа зарим хуучин зүйл, заалтыг эдгээр шинэ нэмэлт өөрчлөлттэй уялдуулан өөрчлөөгүй

⁶ ЭХХШТХ-ийн 31.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁷ ЭХ-ийн 6.6 дугаар зүйлийн 1.2 дэх хэсэг.

⁸ Мөн тэнд, 17.1 дүгээр зүйлийн 3.1 дэх хэсэг.

⁹ Мөн тэнд, 12 дугаар зүйлийн 2.7 дэх хэсэг.



байгаа нь учир дутагдалтай байна. Тухайлбал, 2017 оны ЭХХШТ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 2-т "Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа ... хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг танилцуулна"¹⁰ гэж дурдсан нь, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр мөн Хуулийн 8.3 дугаар зүйлийн 3-т оруулсан "хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй"¹¹ гэсэн заалттай зөрчилдөж байна. Хүний эрхийг дээдлэх зарчмын үүднээс авч үзвэл, Хуулийн 8.3.3 дахь хэсэг нь, Үндсэн хуульд заасан халдашгүй эрхийн үзэл баримтлалд нийцсэн, зөв, зүйтэй заалт юм. Иймд, хуулийн энэ заалтын агуулгад нийцүүлэн, хэрэг танилцуулах тухай хуулийн заалтад "эмзэг мэдээллийг танилцуулахгүй" байхаар хориглож Хуулийн 32.1 дүгээр зүйлийн 2-т өөрчлөлт оруулах нь зохистой санагдаж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хавтаст хэргийг танилцуулах ажиллагаа нь дээр дурдсан хоёр зорилгод хамааралгүй байх тул, яллагдагчийн эмзэг мэдээллийг хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид танилцуулах бодит хэрэгцээ, шаардлага угаасаа байхгүй гэдэг нь тодорхой юм.

Энэ асуудлаар шүүх чухам ямар бодлого, байр суурьтай байгаа, шүүхийн шийдвэр, тогтоолоор ямар жишиг тогтоож байгаа нь, хүний хувийн халдашгүй байдалд хамаарах эмзэг мэдээллийг хамгаалах, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах талаарх хуулийн заалтыг прокурор, мөрдөгч, шүүгч нарын өдөр тутмын үйл ажиллагаандаа зөв хэрэгжүүлж ажиллахад зарчмын чухал ач холбогдолтой байх юм. Шүүхийн энэ талаарх үйл ажиллагааг товчхон авч үзье.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.12 болон ЭХХШТ хуулийн 8.3 дүгээр зүйлийн 3, 29.3 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн "хүний эмзэг мэдээлэл" гэсэн адил нэр томъёо нь нэг ижил утга агуулгатай байх юм. Эрүүгийн хууль болон ЭХХШТ хуульд "...гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал", "сэжигтний хувийн байдал", хувийн мэдээлэл", "яллагдагчийн биеийн байцаалттай холбоотой мэдээлэл", "хүний эмзэг мэдээлэл" гэж өөр өөр байдлаар, ялгаатай томъёолж оруулсан хэдий боловч, эдгээр нь бүгдээрээ ял эдэлсэн байдал гэдэг ойлголтыг өөртөө багтаасан байна. Иймээс, ЭХХШТ хуулийн 32.10 дугаар зүйлийн 3.1-д дурдсан "яллагдагчийн биеийн байцаалттай холбоотой бусад мэдээлэл"¹² гэсэн заалтыг баримтлан, яллах дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт ял эдэлсэн тухай дурдаж, прокурор хэргийг шилжүүлснээр, шүүгдэгчийн хувийн эмзэг мэдээллийг шүүх урьдчилан хүлээн авах нийтлэг практик тогтсон байна. Шүүхүүд, хавтаст хэргийг хүлээн аваад, яллагдагчийн хувийн байдлын талаарх энэ эмзэг мэдээлэлд төдийлөн анхаарал хандуулахгүйгээр, шүүх хуралдаанаар шууд хянан хэлэлцдэг, социализмын үеийн, олон жилийн өмнө тогтсон хуучин журам өнөөг хүртэл үргэлжилсэн хэвээр байна. Хуулийн эдгээр заалтыг, Үндсэн хууль зөрчсөн буруу ажиллагаа гэж үзэж, Цэц, Дээд шүүхээс гаргасан тогтоол, тайлбар байхгүй, энэ журмыг аливаа шүүх "хэвийн ажиллагаа" гэж үзэх ерөнхий жишиг тогтсон байна.

¹⁰ ЭХХШТХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг.

¹¹ Мөн тэнд, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

¹² ЭХХШТХ-ийн 32.10 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг.



III. ПРАКТИКИЙН АЖИЛТНУУДЫН ҮЗЭЛ БОДОЛ

"Хувийн байдлыг тогтоох" ажиллагааг хэрхэн ойлгож хэрэгжүүлж байгаа тухай практикийн ажилтнуудын байр суурийг сонсоход сонирхолтой байв. Зарим прокурор, мөрдөгч нартай энэ Хуульд заасан нэр томъёоны асуудлаар ярилцаж, асууж лавлахад "хувийн байдлыг тогтоох" ажиллагаа нь шинэчилсэн Хуулиар онцгой өөрчлөгдсөн зүйлгүй, олон жилийн өмнө тогтсон хуучин жишгийн дагуу явагдаж байгаа гэдгийг танилцуулж байв¹³. Түүнчлэн, энэ ажиллагааг мөрдөн байцаалтын шатанд хийж, яллагдагчийн эмзэг мэдээллийг хэргийн хамт шүүхэд шилжүүлэх нь хэргийг шүүхээр шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нөхцөл мөн гэж үзэж байгаагаа ихэнх прокурорууд тэмдэглэн хэлж байлаа. Иймээс, гэм буруугийн асуудлыг шүүх шийдвэрлэхэд шүүгчийн ял эдэлсэн байдал хэрхэн нөлөөлөх талаарх асуудалд прокурорууд төдийлөн анхаарал хандуулахгүй, ач холбогдол өгөхгүй байгаа байдал ажиглагдаж байв. Хуульд заасан "Хувийн байдлыг тогтоох, биеийн байцаалтыг цуглуулах, тухайн мэдээллийг шүүхэд шилжүүлэх" ажиллагааны талаарх судалгаа, өгүүлэл, нийтлэлийг интернэтээр хайж үзэхэд энэ талаар хэвлэн, нийтэлсэн зүйлгүй байх тул судалгааны ажлын тухай тоймлон хэлэх боломжгүй байна.

IV. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Ял эдэлсэн талаарх хувь хүний эмзэг мэдээллийг хамгаалах, халдашгүй эрхийг хангах ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний халдашгүй байх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүгчийн хараат бус байдлыг хангах гэсэн хэд хэдэн чухал асуудлуудтай шууд хамааралтай байдаг.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь, Монгол орны хууль тогтоомжийн томоохон эх сурвалжийн нэг болдог. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь ... *дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ*¹⁴" гэж заасан байна. Монгол Улс 1962 онд НҮБ-ын гишүүн орон болсон бөгөөд гишүүн улсын хувьд НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, өөрийн нэгдэн орсон НҮБ-ын аливаа гэрээ, конвенцийг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Тэдгээрийн нэг, чухал ач холбогдолтой олон улсын гэрээ бол Монгол Улс 1974 оны 11 сарын 18-ны өдөр соёрхон баталсан, НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн талаарх олон улсын Пакт юм. Пактын 14 дүгээр зүйлийн 1-д "*Хүн бүр, хараат бус бие даасан, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй*" гэж, 14 дүгээр зүйлийн 2-т "*Эрүүгийн хэрэгт буруутгагдаж буй хэн боловч гэм буруутай нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй*¹⁵" гэж тус тус заасан байна. НҮБ-ын Ерөнхий Асамблейн 1985 оны 40/146 тогтоолоор баталсан Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмуудын 2-т "*Шүүх хэрэг маргааныг шударгаар үйл баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн, хэн нэгнээс, ямар нэг учир*

¹³ Нийслэлийн Хан Уул, Сонгинохайрхан дүүргийн прокуроруудтай 2025.04.02, 2025.04.21-ний өдрүүдэд ярилцлага хийсэн тэмдэглэл.

¹⁴ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

¹⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллага, *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт*, 1966 оны 12 дугаар сарын 19-нд баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон, НҮБ-ын Гэрээний эмхэтгэл, 999 дүгээр боть, 171 дүгээр хуудас. 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.



шалтгаантай хориг хязгаар, зохисгүй нөлөө, урамшуулал, дарамт шахалт, сүрдүүлгээс ангид байдлаар, шууд болон шууд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ¹⁶” гэж заажээ. Пактыг соёрхон баталсан улсын хувьд Монгол Улс энэхүү Пакт, НҮБ-ын Ерөнхий Асамблейн тогтоолоор баталсан “Зарчмууд”-ын эдгээр зүйл заалтуудыг, Үндсэн хуульд заасан дээрх журмын дагуу дагаж мөрдөн, олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлж, иргэдийнхээ эрхийг хангах үүрэг хүлээх юм. Монгол Улс энэ үүргээ хэрэгжүүлэх үүднээс, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 2-т “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Ерөнхийлөгч, ... бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй¹⁷” гэж, салбар хууль болох, Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана¹⁸” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн ... аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно¹⁹” гэж тус тус зааж, Үндсэн хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан тогтоож өгсөн байна. Монгол Улсын олон улсын гэрээ, Үндсэн хууль, салбар хуулиуд нь нарийн харилцан уялдаатай байгаа тогтоолцоог энд графикаар харуулав. Салбар хуулийг Үндсэн хуулийн заалттай нийцүүлэх шаардлагатай гэдэг санаа нь гэнэт гарч ирсэн, шинэ зүйл биш юм. Энэ талаар санал бодлоо илэрхийлж, шинэчилсэн хууль батлагдсаны дараахан бүр 2018 онд, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 10-ын яллагдагчийн хувийн байдлыг тогтоож, тухайн мэдээллийг шүүхэд хүргүүлэх талаарх заалт, түүнийг хэрэгжүүлж байгаа шүүгч, прокурор, мөрдөгчийн үйл ажиллагаа нь, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтад нийцээгүй” гэсэн шүүмж өгүүлэл²⁰ нийтлүүлж байсан болно.

¹⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, *Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмууд*, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/146 дугаар тогтоол, 1985 оны 12 дугаар сарын 13, зарчим 2. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-independence-judiciary>

¹⁷ Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг.

¹⁸ Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021)-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.

¹⁹ *Мөн тэнд*, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг.

²⁰ Ganzorig Gombosuren, *蒙古國新刑事訴訟法中的漏洞*, [in Chinese], *Taiwan Prosecutor Review Journal*, Taipei, Taiwan, January 7, 2019.

График 2: Шүүгчийн хараат бус байдлын талаарх Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, салбар хуулиудын заалт, тэдгээрийн харилцах уялдаа, холбоо

НҮБ-ын Пактын 14. 1, 2:
"Хүн бүр, хараат бус бие даасан, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй"
,"Эрүүгийн хэрэгт буруутгагдаж буй хэн боловч гэм буруутай нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй"

Шүүхийн тухай хуулийн 44.1:
"Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн ... аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно"

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4:
"Монгол Улсын олон улсын гэрээ нь ... дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэнэ, 16 дугаар зүйлийн 14: "шударга шүүхээр шүүлгэх эрхтэй", "Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно".
49 дүгээр зүйлийн 1, 2: "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Ерөнхийлагч, ... бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй"

Үндсэн зарчмууд 2:
"Шүүх хэрэг маргааныг шударгаар үйл баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн, хэн нэгнээс, ямар нэг учир шалтгаантай хориг хязгаар, зохисгүй нөлөө, урамшуулал, дарамт шахалт, сүрдүүлэгээс ангид байдлаар, шүүд болон шүүд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ"

Шүүхийн тухай хуулийн 42.1: "Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана"

V. АНУ-ЫН ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ял шийтгэл оногдуулах, хорих ялын хэмжээг тогтоох, хорих ял эдлэх дэглэм тогтоох, тэнсэх, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг шүүхийн үйл ажиллагаанд шийдвэрлэх нөлөөтэй байдаг тул шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох нь аль ч орны шүүхүүдийн хувьд чухал ач холбогдолтой нөхцөл болдог. Энэ утгаараа, Монгол, Америкийн хуулийн заалт адил агуулгатай харагдаж байна. Харин хуульд тухайлан зааснаас бусад тохиолдолд, гэм буруугийн асуудлыг шүүх шийдвэрлэсний дараа, ял эдэлсэн байдлыг шүүх шалган тогтоох байдлаар Америкийн хуулиар зохицуулсан бол, Монголд, хүнийг сэжигтнээр тооцмогц, түүний ял эдэлсэн байдлыг цагдаагийн байгууллага шалгаж, тухайн мэдээллийг эрүүгийн хэргийн хамт шүүхэд шилжүүлэхээр ЭХХШТ хуулиар журамлан, Америкаас ялгаатай өөр байдлаар хуульчлан тогтоосон байна. АНУ-ын шүүхийн үйл ажиллагааны энэ талаарх журмыг харьцуулан авч үзье.



АНУ-ын хууль тогтоомж нь 50 муж улс болон холбооны улсын хууль журмаас бүрддэг. Ерөнхий шүүгч Деррик Ватсон АНУ-ын шүүхэд алба хашиж байгаагийн хувьд энэ нийтлэлд холбооны улсын хуулиар тогтоосон шүүхийн үйл ажиллагааны журмын талаар тухайлан тайлбарлаж, энэ талаарх олон хууль, тогтоомж, АНУ-ын Дээд шүүхийн уламжлалт жишиг тогтоосон шийдвэрүүдийг танилцуулж, зөвлөмж өгсөн нь чухал ач холбогдолтой байсан болно²¹. Холбооны шүүхийн эдгээр журам нь Америкийн муж улсуудад дагаж мөрдөх хууль, тогтоомжоос ялгаатай болохыг уншигчид болгооно буй зээ. Тухайлбал, АНУ-д хуулиар тогтоосон нөхцөлд хүний хувийн эмзэг мэдээлэл болох ял эдэлсэн байдлыг тогтоож боловч, тухайн мэдээллийг шаардлагагүй тохиолдолд шүүгч болон, тангарагийн шүүгч нар танилцуулдаггүй гэдгийг Ерөнхий шүүгч Ватсон хэлж, Холбооны улсын нотлох баримтын тухай хуулийн 404(b) (1) -д "өөр бусад гэмт хэрэг, зөрчлийн талаарх нотлох баримтыг шүүхэд танилцуулахыг зөвшөөрөхгүй²²" гэсэн заалтыг дурдаж байв. Ерөнхий шүүгч Ватсоны хэлснээр, шүүгдэгчийг барьцаанд гаргахад, шүүхийн харьяанд байдаг, Шүүх хуралдааны өмнөх шатны үйл ажиллагааг хариуцсан хэлтсийн ажилтан, Bail Reform Act гэдэг хуульд зааснаар шүүгдэгчийн хувийн байдал, ял эдэлсэн байдлыг тогтоож, тайлан бэлдэж шүүхэд хүргүүлэх ажиллагааг хийж хэрэгжүүлдэг байна²³.

Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх байдлыг хязгаарлах зорилгоор, Холбооны шүүхэд барьцааны асуудлыг магистрат шүүгч шийдвэрлэж, өөр шүүгч, тухайлбал, дүүргийн шүүхийн шүүгч эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцдэг. Federal Magistrates Act-д дурдсанаар АНУ-ын холбооны шүүхийн магистрат шүүгч нь дүүргийн шүүхийн шүүгчид туслах чиг үүрэг бүхий шүүхийн албан тушаалтан бөгөөд хуульд заасан хүрээнд урьдчилсан ажиллагаа, процессын асуудал, мөн зарим иргэний болон эрүүгийн хэргийг (талуудын зөвшөөрснөөр) хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй байдаг²⁴. Магистрат шүүгчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл дүүргийн шүүхийн шүүхэд гомдол гаргаж хянуулдаг боловч, барьцааны талаар гомдол гаргах нь түгээмэл биш байдаг аж. Энэ нь Монголын хувьд шинэ зүйл бус, өмнө нь хэрэглэж байсан журам юм. Одоо хялбар ажиллагааны тойргийн шүүх цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэх болсон нь Америкийн шүүхийн эл үйл ажиллагаатай төстэй болжээ.

АНУ-ын Үндсэн хуулийн 14 дэх нэмэлт өөрчлөлтөд "...аливаа муж улс нь, хүний амь нас хохироохгүй, хүний эрх эрх чөлөө, эд хөрөнгийн халдашгүй байдлыг зөрчихгүй²⁵" гэж заасан бөгөөд АНУ-ын Дээд шүүх тодорхой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж тогтоол гаргахдаа хүний хувийн нууц нь Үндсэн хуульд заасан энэхүү "халдашгүй байдал"-д мөн хамаарна гэж тогтоож өгсөн байна. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад, шүүгдэгчийн өмнө нь ял шийтгэгдсэн байдлын талаарх мэдээллийг цуглуулах, шүүхэд танилцуулах ажиллагаа нь, Монголын хуульд зааснаас ялгаатай байна. Шүүгдэгчийн өмнө нь ял шийтгэгдсэн байдлыг

²¹ Ерөнхий шүүгч Деррик Ватсон, зөвхөн АНУ-ын шүүхийн үйл ажиллагааны талаарх зарим хууль, тогтоомж, мэдээллийг танилцуулсан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, шүүхийн үйл ажиллагааны талаар ямар нэг дүгнэлт, зөвлөмж санал гаргаагүй болно.

²² Fed. R. Evid. 404(b)(1).

²³ Bail Reform Act, (18 U.S.C. § 3142).

²⁴ 28 U.S.C. § 636 (2018).

²⁵ U.S. Const. amend. XIV, § 1.



зайлшгүй тогтоох энэ талаарх мэдээллийг шүүхэд хүргүүлэх шаардлагатай зөвхөн цөөн хэдэн тохиолдлыг хуулиар тодорхой тогтоож өгсөн байна. Харин эдгээрээс өөр бусад тохиолдолд, тэр талаарх мэдээллийг цагдаа хэргийг мөрдөх явцад шалгах, тухайн мэдээллийг шүүхэд хүргүүлэх үүрэг хүлээдэггүй. Гэм буруугийн асуудлыг шийдвэрлэж байгаа тангарагийн шүүгч жирийн иргэн 12 хүн, эсхүл хэргийг дангаараа шийдвэрлэж байгаа шүүгчид энэ талаар ямар нэг мэдээлэл хүргүүлээгүй байх тул, өмнө нь ял шийтгэгдсэн байдлаас огт хамааралгүйгээр, тэд шүүгчдэгчийн гэм буруугийн асуудлыг хараат бусаар шийдвэрлэх боломжтой байдаг. Иймээс, шүүгчдэгчийн өмнө нь ял шийтгэгдсэн байдал нь, түүний гэм буруугийн асуудлыг шүүх шийдвэрлэхэд ямар нэг сөрөг нөлөө үзүүлнэ гэх эргэлзээ төрөх эрх зүйн үндэслэлгүй юм.

Эрүүгийн хэргийг гэм буруугийн асуудлыг, зөвхөн бодит факт, нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах тангарагийн шүүгч хүмүүсийн сэтгэл зүйн хараат бус байдлыг хангах зорилгоор Америкийн тангарагийн шүүхийн тогтолцоонд олон жилийн турш, тогтмол хэрэглэж ирсэн нэг сонгодог жишээг энд дурдъя. АНУ-ын Үндсэн хуулийн 6,7 дахь нэмэлт өөрчлөлтөд зааснаар гэмт хэрэгт холбогдсон хүн хэргээ тангарагийн шүүгч нараар шийдвэрлүүлэх эрхтэй байдаг²⁶.

Энэ заалтаас уламжлан, жирийн иргэн тангарагийн шүүгч 12 хүн шүүгчдэгчийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэж, Үндсэн хуульд заасан иргэний энэхүү эрхийг хангах үүргийг гүйцэтгэдэг. Талуудын оролцоотойгоор шүүх 14 хүнийг сонгох боловч, зөвхөн 12 хүн тангарагийн шүүгчээр хуралдаанд оролцож, үлдэх хоёр хүн нь хуралдааны явцад шүүхийн танхимд байнга хүрэлцэн ирж ажиглах үүрэгтэй байна. Тангарагийн шүүгч нарт шүүх хурал дуустал, хэргийн талаарх аливаа мэдээ, мэдээллийг радио, ТВ-ээр үзэх, сонин сэтгүүл, мэдээллийн бусад хэрэгслээс үзэж, танилцахыг хуулиар хориглосон болохыг тэдэнд зааварчилж, сануулдаг. Хэрэв хэн нэг нь энэ журмыг зөрчвөл түүнийг чөлөөлж, тангарагийн нөөц шүүгчээр сонгогдсон өөр бусад хүнийг шүүх хуралдаанд оруулж, шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулдаг. Америкийн бүхий л муж улс мөн ийм адил төстэй журамтай байна. Энэ журам нь тангарагийн шүүгч жирийн иргэдийн Үндсэн хуульд заасан мэдээлэл авах эрхийг шүүх хуралдааны хугацаанд хязгаарлаж байгаа харагддаг боловч, тангарагийн шүүгчээр ажиллаж, Үндсэн хуульд заасан иргэний үүргээ гүйцэтгэж байгаа тул шүүхийн зөвлөмжийн дагуу иргэд өөрсдөө тухайн эрхээсээ сайн дураараа татгалздаг.

Энэ журам нь, тангарагийн шүүгч нар аливаа хэлбэрээр, хэргийн талаарх ямар нэг мэдээ, мэдээллийг авч, шүүгчдэгчийн гэм буруугийн асуудлыг тухайн мэдээллийн нөлөөнд автаж шийдвэрлэхээс сэргийлэх, тангарагийн шүүгч нарын хараат бус байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэх нэг чухал арга хэлбэр болдогоороо онцлог байна. Тангарагийн шүүгч нарын үйл ажиллагааг зохицуулсан хуулийн энэ заалт шүүгч нарт хамааралгүй боловч, ёс зүйн журам нь, шүүгчийн хувьд хараат бус, шударга байдлаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хангах гол нөхцөл болдог. Түүнчлэн, зайлшгүй шаардлагатай тохиолдолд, шүүгчдэгчийн ял эдэлсэн байдлын талаарх мэдээлэлтэй урьдчилан

²⁶ U.S. Const. amend. VI and VII.



танилцсан ч, шүүгч нь тухайн мэдээллийн нөлөөнд автахгүйгээр, гэм буруугийн асуудлыг хөндлөнгийн байр, сууринаас шийдвэрлэх, олон нийтийн итгэлийг хүлээж чадсан, эрх зүйн хараат бус орчин, тогтолцоог Америкад бий болгосон гэж үздэг байна.

АНУ-ын хуульд ял шийтгэл оногдуулах ерөнхий нөхцлийн талаар тодорхой дурдаж, "Ял шийтгэл оногдуулах Холбооны улсын зөвлөмж" (цаашид Зөвлөмж) хуулийг харгалзан үзэхээр заасан байна²⁷. Хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд, шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон тохиолдолд, түүнд ял шийтгэл оногдуулах хуралдааныг шүүх товлодог. Ял шийтгэл оногдуулах тогтоолыг шүүх гаргах боловч, ял шийтгэл оногдуулахад харгалзан үзвэл зохих Зөвлөмжид дурдсан тодорхой нөхцөл байдлыг шүүгч өөрөө шалган тогтоох биш, харин шүүхийн харьяанд байдаг АНУ-ын тэнсэн хянах ажиллагааг хариуцсан газрын ажилтнууд энэ ажиллагааг хэрэгжүүлдэг. Тухайн газрын ажилтнууд нь шүүгдэгчийн хувийн байдлыг нарийвчлан шалган тогтоосон тайлан-мэдээллийг, оногдуулах ялын талаарх саналын (Pre-sentence report) хамт шүүхэд хүргүүлдэг журамтай байна. Энэ тайланг шүүх хуралдаан товлосны дараа, 3-4 сарын хугацаанд хийж гүйцэтгэдэг бөгөөд тайлан нь нууцад хамаарах тул зөвхөн шүүх, болон талууд үзэж танилцах боломжтой, харин олон нийтэд ил болгох боломжгүй байдаг. Талууд, шүүгчдэгчийн хувийн байдал, ял эдэлсэн эсэх, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх зэрэг бусад эмзэг мэдээллийг үзэж танилцаад, оногдуулах ялын талаарх өөрсдийн тодорхой саналыг мөн шүүхэд хүргүүлдэг. Шүүгдэгчийн насанд хүрээгүй байхдаа болон ял шийтгэгдсэн бүхий л түүхийг тайланд тусгадаг боловч зөвхөн сүүлийн 10 жилийн хугацаанд ял эдэлсэн байдал нь Зөвлөмжид дурдсан журмын дагуу оноог тооцоход ач холбогдолтой байдаг.

Тухайн санал нь зөвхөн зөвлөмж тул шүүх заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй боловч, түүнийг харгалзан авч үздэг. АНУ-ын Сенатаас, Ял шийтгэлийн шинэтгэлийн тухай хуулиар 1984 онд, Америкийн ял шийтгэл хариуцсан хороог холбооны шүүхийн тогтолцоонд багтаан байгуулжээ. Ерөнхийлөгчийн санал болгосноор Сенат нь, 7 гишүүнтэй хороог 6 жилийн хугацаагаар байгуулдаг. Хорооны 3 гишүүн нь холбооны шүүхийн шүүгч байх журамтай байна. Одоогийн байдлаар шүүгч Картлон Рэвэс Хороог даргалж байна. Тус Хорооноос 1984 онд, Холбооны улсын ял шийтгэл оногдуулах зөвлөмжийг гэмт хэрэгт оногдуулах ялын 43 дундаж түвшин, мөн шүүгдэгчийн өмнө нь ял шийтгэгдсэн байдлыг оноогоор тодорхойлсон 6 зэрэглэл гэсэн хоёр гол үзүүлэлтийг баримтлан, оногдуулах ял шийтгэлийг шүүх харьцуулан тооцон тогтоох тусгай хүснэгтийг батлан гаргасан байна. Ерөнхий шүүгч Ватсоны тайлбарласнаар, эрүүгийн хэргийн төрөл бүрд ялын дундаж түвшинг тогтоосон бөгөөд хэргийн нөхцөл байдлаас хамааруулан энэ түвшингээс дээгүүр эсхүл доогуур ял оногдуулж болохоор Зөвлөмжид заасан байна (тухайлбал, гэмт хэрэг үйлдэхдээ зэвсэг хэрэглэсэн бол 2 оноо, хүний биед гэмтэл учруулсан бол 2 оноо тус тус нэмэгдэж, ялыг хүндрүүлнэ). Зарим тохиолдолд, Зөвлөмжид зааснаас илүүтэй их хэмжээний торгууль оногдуулахаар хуульд заасан (тухайлбал, мансууруулах бодистой холбогдох гэмт хэрэгт оногдуулах торгууль 10,000,000 ам. доллар)

²⁷ 18 U.S.C. § 3553 (2018).



байгаа боловч, шүүгдэгч нарт их хэмжээний хөрөнгө, мөнгө байхгүй байдаг тул шүүх энэхүү өндөр торгуулийг төдийлөн өргөн хэрэглэдэггүй байна. Цөөн бус тохиолдолд, оногдуулах ялын доод хэмжээг хуулиар хатуу тогтоож өгсөн байдаг тул, шүүгч нар хуулийг дагаж, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Тухайлбал, мансууруулах бодистой холбогдох гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг олон тохиолдолд, 5 эсхүл 10 жил байхаар хуулиар тогтоосон тул, Зөвлөмжийн заалтаас хамааралгүйгээр, шүүх тухайн доод хэмжээг удирдлага болгон ял шийтгэл оногдуулдаг байна. Зөвлөмжийн хавсралт хүснэгтэд зааснаар, 1 дүгээр түвшинд хамаарах гэмт хэрэг үйлдсэн, 1 дүгээр зэрэглэлд хамаарах оноотой хүнд, 0–6 сар хүртэл хорих ял оногдуулах, 43 дугаар түвшинд хамаарах гэмт хэрэг үйлдсэн, 6 дугаар зэрэглэлд хамаарах оноотой хүнд бүх насаар нь хорих ял оногдуулах боломжтойг зөвлөмж болгосон байна²⁸. Түүнчлэн, энд 200 - 500,000 ам.доллар хүртэлх торгууль болон тэнссэн ялыг цуцлан ял оногдуулах ажиллагааны талаар зөвлөмж болгосон хүснэгтийг багтаасан байдаг. АНУ-ын Техас мужид явуулсан сургалтын явцад Дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн шүүгч нар "Ял шийтгэл оногдуулах Холбооны улсын зөвлөмж"-ийн тухай цөөн бус удаа асууж, сонирхож байсан байдлыг харгалзан, энд Зөвлөмжийн талаар ялимгүй дэлгэрүүлж дурдсан болно.

Ийнхүү, шүүгдэгчийн ял шийтгэгдсэн байдлыг тогтоох ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг шүүхийн ажилтанд олгох байдлаар ерөнхийлөн зохицуулж, харин зөвхөн тодорхой тохиолдолд, гэм буруугийн асуудлыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхийн өмнө, хэргийг мөрдөн шалгах зарим үе шатанд, шүүгдэгчийн ял шийтгэгдсэн байдлыг мөрдөгч шалгаж, прокурор шүүхэд урьдчилан танилцуулах журмыг хуулиар тогтоосон байна. Тухайлбал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, нотлох баримттай холбогдсон асуудлыг шүүхийн урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэх, тохиролцоо хийх (хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх) зэрэг тохиолдолд шүүгдэгчийн ял шийтгэгдсэн байдлыг шүүхэд урьдчилан танилцуулж, мэдээлэх шаардлагатай байдаг. Америкийн хуулийн энэ хэсэг нь Монголын хуулиар тогтоосон журамтай адил төстэй байна. АНУ-ын Үндсэн хуульд заасан тодорхой жишгээс харвал, зөвхөн хуульд заасан тодорхой болзол, шалгуурыг хангасан тохиолдолд л хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хатуу нөхцөлтэй байдлаар хуульчилсан байдаг аж. Үндсэн хуулийн 4 дэх нэмэлт өөрчлөлтөд, хүний бие, орон байр, бичиг баримт, эд хөрөнгө халдашгүй байна гэж зааж,

- а) үндэслэл бүхий учир шалтгааныг заасан,
- б) бодитой болохыг тангарагласан (хууль сануулах),
- с) нэгжлэг хийх газар, саатуулах хүн, хураан авах зүйлийг нарийвчлан

тодорхой зааснаас бусад тохиолдолд нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг явуулах зөвшөөрөл олгохгүй²⁹ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд хүнийг нэгжих, орон байранд нэгжлэг хийх ажиллагаа явуулахдаа заавал зөвшөөрөл авах шалгуур тогтоож, улмаар тухайн зөвшөөрлийг шүүх олгох шалгууруудыг салбар хуульд бус харин бүр Үндсэн хуульд тодорхой зааж, хүний

²⁸ U.S. Sent'g Comm'n, Guidelines Manual § 3E1.1 (Nov. 2025).

²⁹ U.S. Const. amend. IV.



халдашгүй эрхийг хамгаалах бодит тогтолцоог баталгаажуулж өгснөөрөө онцлог байна.

VI. ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ ЭРХИЙН ОНОЛ

Үндсэн хуульд заасан халдашгүй эрх нь төрийн хууль бус оролцооноос хувь хүнийг хамгаалах, төрийн эрх мэдлийг хязгаарлах, засаглалын салбаруудын бие даасан байдлыг баталгаажуулах зорилго, үзэл баримтлалтай онолд үндэслэсэн бөгөөд энэ нь философи, Үндсэн хуулийн онол, олон улсын хүний эрх, мэдээллийн эрх зүйн хөгжлөөс үүссэн олон эх сурвалжтай, гүнзгий ойлголт юм.

Хүний халдашгүй эрх нь, төр бол эрх олгогч биш, харин хамгаалагч байх гэсэн байгалийн эрхийн (natural rights theory) онолд тулгуурладаг. Байгалийн эрхийн онол нь хүний тодорхой эрхүүд төрөөс үл хамааран, хүн болж төрснөөр заяагдсан эрх гэж үздэг философи юм. Тухайлбал, философичид, гүн ухаантан Жон Лок, Томас Хоббис, Жан Жаск Руссо нар, амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх зэрэг эрхүүд нь төрөөс олгогдсон биш, харин хүний салшгүй эрх гэж үздэг. Байгалийн эрхийн онол нь философийн үндсэн эх сурвалж болдог, харин түүнд суурилсан халдашгүй эрхийн онол нь тэдгээр эрхийг төрийн эрх мэдлээс хамгаалах институцийн болон процессын баталгааг бий болгож, Үндсэн хуулийн эрхийг хэрэгжүүлэх механизм болж үйлчилдэг. Тухайлбал, Үндсэн хуульд заасан халдашгүй эрх нь хүний:

1. амь нас,
2. бие махбод,
3. нэр төр,
4. хувийн орон зай,
5. хувийн мэдээлэлд (informational privacy)

төрөөс дур мэдэн халдаж, хязгаарлахыг хориглодог. Энэ агуулгаараа бидний авч үзэж байгаа хүний хувийн эмзэг мэдээллийг хамгаалах зарчим нь, аливаа нэг зохиомол зүйл бус харин, байгалийн эрхийн онолоос уламжлалтай Үндсэн хуулиар баталгаажсан, салбар хуулиудаар дамжуулан хэрэгжүүлэх халдашгүй эрхийн нэг хэсэг болох юм.

Хувийн халдашгүй эрхийн онолын эх суурийг бүр эрт 1890 онд тавьж, Уоррен, Брандейс нар сонгодог бүтээл болох "The Right to Privacy" өгүүлээ нийтлүүлж байжээ. Тэд, "аливаа хүн, бусдаас хамааралгүйгээр бие дааж, өөрийнхөөрөө байх эрх"-ийн (Right to be let alone) тухай ойлголтыг анх танилцуулж, жишиг хуулийн тогтолцоотой эрх зүйн системийн хүрээнд бие даасан эрх болгохыг шаардаж, хүний хувийн амьдралд хэвлэл мэдээлэл болон бусад этгээдийн хөндлөнгийн хэт оролцооноос хамгаалах эрх зүйн үндсийг боловсруулж байжээ³⁰. Энэхүү өгүүлэл хожим нь хувийн мэдээллийн халдашгүй байдлын (informational privacy) үзэл баримтлалд философийн үндэс суурь нь болж хөгжсөн бөгөөд энэхүү түүхэн онол нь өөрийн талаарх мэдээлэлдээ хувь хүн өөрөө хяналт тавих эрхтэй гэсэн гол зарчимд тулгуурлаж байдаг.

³⁰ Дам эшлэл: Samuel D. Warren and Louis Brandeis "The Right to Privacy" (Harvard Law Review 193, 1890), https://groups.csail.mit.edu/mac/classes/6.805/articles/privacy/Privacy_brand_warr2.html.



Энэхүү онолыг олон улсын хэмжээнд хөгжүүлж, хувь хүний халдашгүй эрхийг баталгаажуулж, НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байр, захидал харилцаа, нэр төр, алдар хүндэд нь дур мэдэн, хууль бусаар халдаж болохгүй", "Ийм халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй" гэж заасан байна³¹.

Хожим нь ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх, 1983 онд шийдвэрлэсэн "Хүн амын тооллогын хэрэг" -ийн талаарх тогтоолдоо "өөрийн мэдээллийн талаар хувь хүн өөрөө шийдвэр гаргах эрх" нь (right to informational self-determination) хүний нэр төр, хувь хүний чөлөөт хөгжлийн үндсэн баталгаанаас үүсэн гарна гэж дурдсан байна³².

Ял эдэлсэн талаарх хүний хувийн эмзэг мэдээллийг шаардлагагүй нөхцөлд цагдаа цуглуулах, тухайн мэдээллийг шүүхэд шилжүүлэхээр журамласан ЭХХШТ хуулийн заалт нь Монголын Улсын Үндсэн хууль, дээр дурдсан эрх зүйн түгээмэл онол, олон улсын гэрээ, олон улсын шүүхийн шийдвэрт ийнхүү нийцээгүй байдалтай байгаа нь тодорхой харагдаж байна.

VII. ДҮГНЭЛТ, САНАЛ

Эрүүгийн эрх зүйн салбарын өнөөгийн хууль, тогтоомж нь хуучин Зөвлөлт холбоот улсын эрүүгийн хуулиудаас хуулбарлан, орчуулж, социалист үзэл сурталд нийцүүлж батламжилсан, төрийг дээдэлсэн систем, чиг баримжаатай хэвээр байна. УИХ, 1992 оны Үндсэн хуулийн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх үзэл баримтлалд нийцүүлэн, эрүүгийн эрх зүйн салбарын суурь зарчмуудыг өөрчлөх, томоохон бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадахгүй байсаар өнөөдрийг хүрчээ. Гадаад улс орны зарим нэг тэргүүлэх арга хэлбэрийг хагас дутуу танилцуулсан боловч, тэдгээр нь Монголын эрүүгийн эрх зүйн тогтолцооны социалист чиг баримжаа, үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөх хэмжээнд хүрээгүй байна. Энэ өгүүлэлд тухайлан авч үзэж байгаа, хүний халдашгүй эрхийг хуулиар хамгаалах үйл ажиллагаа ч мөн л тэр түвшинд байна. Д.Мягмардоржтой хийсэн ярилцлагад, Монголын Криминологичдын холбооны судлаач С.Номынбаясгалан "Бид өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд гадаад улсын хуулийг маш ихээр импортоор авсан. Өөрөөр хэлбэл, импортоор маш олон онолыг авсан гэсэн үг. Орчуулгын хуулиудыг шууд хуулж хэрэглэсэн... Хууль тогтоох үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулиа дээдлэх үзэл санаа, түүний агуулгад нийцсэн шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах соёл, ухамсар эрх зүйн хувьд болон улс төрийн хувьдаа ч бүрэн төлөвшиж чадаагүй³³" гэж хэлсэн нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй, гашуун боловч туйлын үнэн ажгуу.

³¹ НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 17 дугаар зүйлийн 1, 2 дэх хэсэг.

³² Federal Constitutional Court of Germany (Bundesverfassungsgericht), Judgment of 15 December 1983, 1BvR 209/83 et al., 65 BVerfGE 1(Census Act Case), https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Entscheidungen/EN/1983/12/rs19831215_1bvr020983en.html.

³³ Д.Мягмардорж, "Ерөнхий сайдын томилгоо хүртэл Үндсэн хуулийн зарчим зөрчсөн", www.news.mn, 2016, 2 дахь тал, (Сүүлд үзсэн: 2016.01.14).



Хоёр орны хуульд заасан байдлыг харьцуулан үзэхэд, шүүгдэгчийн хувийн байдлыг шалган тогтоох ажиллагааг шүүхэд өөрт нь харьяалуулсан Америкийн дээр дурдсан загвар нь, хэд хэдэн давуу талтай харагдаж байна.

1. Энэ тогтолцоо нь, иргэний хувийн эмзэг мэдээлэл, халдашгүй байдлын талаарх Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулж өгч байгаагаараа хүний, эрх эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдолтой байх юм.
2. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруугийн талаарх асуудлыг зөвхөн шүүх, хөндлөнгийн оролцоо, нөлөөлөлгүйгээр, хараат бус байдлаар шийдвэрлэх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэх боломж бүрдүүлж байна.
3. Зөвхөн шаардлагатай тохиолдолд ял шийтгэгдсэн байдлыг тогтоох ажиллагааг цагдаагийн байгууллага хийх, шүүгдэгчийг гэм буруутай гэж тооцсон тохиолдолд, шүүхийн ажилтан, түүний хувийн байдлын талаарх мэдээллийг цуглуулах, оногдуулах ялын талаарх саналыг бэлтгэж шүүхэд хүргүүлэх байдлаар (хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд, энэ саналыг бэлтгэх шаардлагагүй болно) журамласан зэрэг нь, шүүх, цагдаагийн байгууллагын цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх боломжийг бий болгосон давуу талтай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан дагуу, яллагдагчийн ял эдэлсэн тухай мэдээллийг прокуророос шүүхэд шилжүүлж байгаа энэ ажиллагаа нь, шүүгдэгчийн гэм буруугийн асуудлыг нотлох баримтад үндэслэн шийдвэрлэхээс бүр өмнө, шүүгдэгчийн хувийн байдлын талаарх сөрөг мэдээллийг прокуророос шүүхэд хүргэж, "тухайн этгээд өмнө нь гэм хэрэг үйлдсэн тул энэ гэмт хэргийг мөн үйлдсэн байх магадлалтай" гэх урьдчилсан дүгнэлт, сэтгэлгээг шүүгчид төрүүлэх боломж, нөхцлийг бий болгосон байна. Энэ үйл ажиллагаа нь, гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргах шүүгчийн хараат бус ажиллагаанд сэтгэл зүйн талаас туйлын сөрөг нөлөө үзүүлж, Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4-т "Эрүүгийн хариуцлага хүлээж дуусгавар болсон нь хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд хүний эрх зүйн байдлыг дордуулах үндэслэл болохгүй"³⁴ гэж заасныг зөрчихөд хүргэх үр дагавартай харагдаж байна. Өөрөөр хэлбэл, гэм буруугийн асуудлыг шүүх шийдвэрлэхдээ, ял эдэлсэн байдлыг "хүний эрх зүйн байдал"-ыг дордуулах үндэслэл болгон ойлгож, хэрэглэх урьдчилсан нөхцлийг хуулиар бий болгосон гэх логик дүгнэлтэд хүргэж байна. Хөндлөнгийн нөлөөнд байгаа харагдах ийм орчин нөхцөлд, гэм буруугийн асуудлыг шүүгч шийдвэрлэх үүрэг хүлээж байгаа нь, нийгэм, олон нийт шүүхэд итгэл хүлээлгэж, шударга шийдвэр гаргана гэдэгт эргэлзээ төрүүлэх нөхцөл болох юм. Хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлж байгаа шүүгч, прокурорын ажиллагаа нь ч өөрөө мөн хууль зөрчсөн харагдаж байна.

ЭХХШТ хуулийн дээр дурдсан заалтууд нь Үндсэн хуулийн хүний халдашгүй эрх, шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн асуудлыг шийдвэрлэх арга хэлбэрийн талаар зарим санал хэлье.

³⁴ ЭХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.



1. Дээр дурдсан үндэслэл, тайлбар, олон улсын жишиг зэргийг харгалзан, шүүгдэгчийн хувийн байдлын талаарх эмзэг мэдээллийг цагдаа цуглуулж, гэм буруугийн асуудлыг шийдвэрлэхээс өмнө тухайн мэдээллийг шүүхэд шилжүүлэхээр хуулиар тогтоосон журмыг өөрчлөх нэмэлтийг ЭХХШТ хуульд оруулж, Улсын Их хурал, Үндсэн хуулийн "халдашгүй байх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрх", "шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал"-ын талаарх заалтад нийцүүлэх шаардлагатай байна.
2. Хуулиар тогтоосон журмын дагуу, УДШ, УЕПГ нь Үндсэн хуулийн Цэцэд хандан, энэ асуудлыг нэг тийш болгон шийдвэрлүүлэх бас нэг гарц байж болох юм. ЭХХШТ хуулиар 1.6 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт "Хэрэг маргааныг шийдвэрлэхэд...хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл... УДШ, Улсын ерөнхий прокурор Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана³⁵" гэж энэ журмыг тодорхой хуульчлан тогтоож өгсөн байна. Хувийн эмзэг мэдээлэлд хамаарах, шүүгдэгчийн ял эдэлсэн байдлыг урьдчилан танилцуулах эдгээр журмууд нь Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг шүүгч, прокурорууд авч үзэж, ЭХХШТ хуулийн өөрийн нь энэ заалтыг хэрэглэн Цэцэд хандаж, шийдвэрлүүлэх боломжтой байна. Энэ нь Үндсэн хуулийг жирийн шүүх, прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа хэрэглэж, Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах өргөн хүрээтэй, цоо шинэ ажиллагааг эхлүүлэх нэн чухал, зарчмын алхам болох юм.

Хүний эмзэг мэдээллийг шаардлагагүй тохиолдолд цуглуулах, шүүхэд урьдчилан танилцуулах журмыг зогсоох замаар, УИХ-аас зохих хуулиудад өөрчлөлт оруулах нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах боломж нөхцлийг бий болгох төдийгүй, НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн талаарх олон улсын Пакт, НҮБ-ын Ерөнхий Асамблейн 1985 оны 40/146 тогтоолоор баталсан Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмуудын заалтуудыг хэрэгжүүлэхээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ нь, Монгол Улс зохих журмын дагуу биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай ажиллагаа байх болно.

³⁵ ЭХХШТХ-ийн 1.6 дугаар зүйлийн 3.4 дэхь хэсэг.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль. 1787 он.
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль. 2021 он.
4. Эрүүгийн хууль. 2015 он.
5. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. 2021 он.
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
7. Холбооны улсын нотлох баримтын тухай хууль. 2024 он.
8. Батлан даалтын шинэчлэлтийн хууль. 1984 он.
9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он.
10. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүхийн 1983 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 209/83 шийдвэр.
11. Ял шийтгэл оногдуулах Холбооны улсын зөвлөмж. 2018 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж

1. Д.Мягмардорж, "Ерөнхий сайдын томилгоо хүртэл Үндсэн хуулийн зарчим зөрчсөн", 2016.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Ganzorig Gombosuren, 蒙古國新刑事訴訟法中的漏洞, [in Chinese], Taiwan Prosecutor Review Journal, Taipei, Taiwan, 2019.
2. Samuel D. Warren and Louis Brandeis. The Right to Privacy (Harvard Law Review). 1890.

4. Цахим эх сурвалж

1. Эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://legalinfo.mn/mn>
2. Нэгдсэн Үндэстний байгууллагын цахим хуудас: https://www.ohchr.org/en/ohchr_homepage
3. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн цахим хуудас: https://www.bundesverfassungsgericht.de/EN/Home/home_node.html
4. <https://news.mn/>
5. https://groups.csail.mit.edu/mac/classes/6.805/articles/privacy/Privacy_brand_warr2.html